**"ЦЭЭЦЭЭ-ИМПЕКС" ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот-1235, Чингэлтэй дүүрэг19-р хороо, Шадивлан 1-90 404 тоот,
Утас: 976-91915431
Э-шуудан: www.tseetsee_impex@yahoo.com

2022.11.01 № 123

танай ____________-ны №____________ -т

**Нийслэлийн Байгаль орчны газарт**

**Хүсэлт гаргах нь**

Манай компани Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших 19/М017 тоот тусгай зөвшөөрөлтэй Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлж байна.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлантай танилцаж дүгнэлт гаргаж өгнө үү.

**ХҮНДЭТГЭСЭН:**

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ** **/ Э.ГАНТУЯА /**

“Цээцээ импекс” ХХК

# Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын
# 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

*/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: 19/М017/*

*/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 2804816/*

**Хянасан:**

“НБОГ”, ХБОБНХэлтэсийн мэргэжилтэн: ....................................................../Ж.Батзолбоо/

**Биелэлтийн тайлагнасан:**

“Цээцээ импекс” ХХК -ийн

Гүйцэтгэх захирал:.................................................................................... / Э.Гантуяа /

Байгаль орчны мэргэжилтэн:................................................... /Т.Төрбат/

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА....3
1.1. Төслийн байршил: ....3
1.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл ....4
4
1.3. Төслийн үйлдвэрлэлийн нөөц:....4
1.4. Төслийн хүчин чадал:....4
1.5. Тэсэлгээний ажил: ....5
1.6. Ухаж, ачих процесс ....5
1.7. Уурхайн тээвэр ....5
1.8. Овоолго ....5
1.9 .Усан хангамж....7
1.10. Агуулах....6
1.11. Засвар механикийн барилга байгууламж....6
1.12. Цахилгаан хангамж ....6
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....7
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....8
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....8
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....9
6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....9
7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....9
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....9
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....11
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ....11
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 14
12. .ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....16

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1. Үзүүлэлт /"Цэзцээ Импекс" ХХК/ 3
Хүснэгт №2. Уурхайн солбилцол 3
Хүснэгт №3. Ил уурхайн барилга байгууламжууд 6
Хүснэгт №4. Зам талбайн усалгааны норм 6
Хүснэгт №5. Нийт усны хэрэглээ 6
Хүснэгт №6. Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 7
Хүснэгт №7. Дүйцүүлэн хамгаалалын биелэлт 8
Хүснэгт №8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт 9
Хүснэгт №9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт 11
Хүснэгт №10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт 12
Хүснэгт №11. БОМТБ-ийн хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 16
Хүснэгт №12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зарсан зардал 16

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг ........ 4
Зураг №2. Уурхайд тавьсан, тэмдэг тэмдэгжүүлэлтийн зураг ........ 8
Зураг №3. Галын аюулгүй байдлын тухай сургалт зохион байгуулж буй фото зураг ........ 10
Зураг №4. Уурхай дахь галын булангийн фото зураг ........ 10
Зураг №5. Хог хаягдлын хашаалсан байдал ........ 11
Зураг №6. Усны дээж авч байгаа үеийн зураглал ........ 13
Зураг №7. Хөрсний дээж авч байгаа үеийн зураг ........ 13
Зураг №8. Ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас олгосон байдал ........ 15
Зураг №9. Ажилчдын эмчийн үзлэгт орж байгаа байдал ........ 15

# 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

***Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:*** “Цээцээ импекс” ХХК

***Төслийн зорилго:*** Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын барилгын чулууг олборлож, бутлан ангилан, сайн чанарын дайрга зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

***Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга***

*Хүснэгт №1. Үзүүлэлт /”Цээцээ Импекс” ХХК/*

| № | Үзүүлэлтүүд | | |
|---|---|---|---|
| 1 | Аж ахуйн нэгжийн нэр | | “Цээцээ Импекс” ХХК |
| 2 | Улсын бүртгэлийн дугаар | | 9011137041 |
| 3 | Ордын нэр | | Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд |
| 4 | Ордын байршил | Нийслэл/Хот/ Аймаг | Улаанбаатар |
| 5 | | Сум/Дүүрэг | Хан-Уул |
| 6 | Ашигт малтмалын төрөл | | Барилгын чулуу |
| 7 | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | | 19/М017 |
| 8 | Ашиглалт эхэлсэн огноо | | 2019 |
| 9 | Аж ахуйн нэгжийн хаяг | Аймаг/Хот | Улаанбаатар |
| 10 | | Сум/Дүүрэг | Чингэлтэй |
| 11 | | Баг/Хороо | 10,12-р хороо |
| 12 | | Гудамж/Байр | Шадивлан 1-90 404 тоот |
| 13 | | Гар утас | 91915431 |
| 14 | Захирлын хаяг | Нэр | Гүйцэтгэх захирал Э.Гантуяа |
| 15 | | Гар утас | 91915431 |
| 16 | | Электрон шуудан | Tseestee_impex@yahoo.com |

### 1.1. *Төслийн байршил:*

“Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг.

- ✓ Засаг захиргаа: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
- ✓ Ордын нэр: "Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд"
- ✓ Ашигт малтмалын үндсэн төрөл: Барилгын чулуу
- ✓ Трапецийн номенклатур: L-48-10
- ✓ Талбайн нийт хэмжээ: 54.07 га

*Хүснэгт №2. Уурхайн солбилцол*

| № | Газарзүйн солбицол | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Өргөрөг | | | Уртраг | | |
| 1 | 106 | 43 | 41.03 | 47 | 48 | 40 |
| 2 | 106 | 43 | 39.7 | 47 | 48 | 50.87 |
| 3 | 106 | 43 | 49.59 | 47 | 48 | 58 |
| 4 | 106 | 44 | 11.02 | 47 | 48 | 58 |
| 5 | 106 | 44 | 11.3 | 47 | 48 | 40 |
| 6 | 106 | 42 | 50 | 47 | 48 | 40 |
| 7 | 106 | 43 | 36.25 | 47 | 48 | 40 |
| 8 | 106 | 43 | 32.78 | 47 | 48 | 49.15 |
| 9 | 106 | 43 | 30.35 | 47 | 48 | 51.35 |
| 10 | 106 | 43 | 22.44 | 47 | 48 | 52.19 |
| 11 | 106 | 43 | 15.21 | 47 | 48 | 50.57 |
| 12 | 106 | 43 | 13.7 | 47 | 48 | 42.09 |
| 13 | 106 | 43 | 11.15 | 47 | 48 | 42.56 |
| 14 | 106 | 43 | 5.89 | 47 | 48 | 47.97 |
| 15 | 106 | 43 | 2.95 | 47 | 48 | 48.52 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | 106 | 43 | 0.95 | 47 | 48 | 42.73 |
| 17 | 106 | 42 | 59.27 | 47 | 48 | 42.06 |
| 18 | 106 | 42 | 50 | 47 | 48 | 42.06 |

### 1.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Нийслэлийн засаг даргын тамгын газраас "Цэцэц импекс" ХХК-д 54.07 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож 19/М017 дугаар бүхий гэрчилгээг 2019 оны 02 сарын 12-ны өдөр олгосон байна.




*Зураг № 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг*

### 1.3. *Төслийн үйлдвэрлэлийн нөөц:*

Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан B' зэргээр 14,021.6 мян.м$^3$ буюу 37,157.1 мян.тн дайрга болж байна.

Ил уурхайн талбай: Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын уурхайн ашиглалтаар 2 ухаш үүснэ. Талбай-1 дэх ил уурхай ойролцоогоор 800м урттай, 350м өргөнтэй байх бөгөөд 18.3 га талбайг хамарсан ухаш үүсэх бол талбай-2 дахь ил уурхай ойролцоогоор 640 м урттай, 390 м өргөнтэй байх бөгөөд 23.8 га талбайг хамарсан ухаш болох юм.

Ил уурхайн гүн: Ил уурхайн ёроолын түвшин талбай-1 хувьд +1340м бол талбай-2 хувьд +1360 м байх бөгөөд ил уурхайн хамгийн их гүн нь харгалзан 63м, 70 м байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц: Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд нь 18 блок бүхий В зэргээр 15,736.05 мян.м$^3$ дайрга, С зэргээр 3,664.27 мян.м$^3$ дайрга, нийт В+С зэргээр 19,400.32 мян.м$^3$ дайрганы нөөц баталгаажуулсан байна. Үүнээс уурхайн хүрээ хязгаарт В зэргээр 13,848.69 мян.м$^3$ дайрга, С зэргээр 609.75 мян.м$^3$ дайрга, нийт В+С зэргээр 14,458.44 мян.м$^3$ дайрга хамрагдаж байна.

### 1.4. *Төслийн хүчин чадал:*

Төсөл боловсруулагчаас өгсөн ажлын даалгаврын дагуу ил уурхайн хүчин чадлыг сонгон авсан. Жилд дунджаар 95 мян.м$^3$ хөрс хуулж 516.3 мян.м$^3$ дайрга олборлоно. Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын уурхайн хөрс хуулалт, олборлолтын ажлыг 2019 оны 6 сараас эхлэхээр төлөвлөсөн ба цаашдаа уурхай нь жил бүрийн 4 сараас 11-р сар хүртэл ажиллана.

### 1.5. *Тэсэлгээний ажил:*

Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат "ANFO", "Аянга" зэрэг энгийн найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ

Уулын ажлын төлөвлөлт:

Уурхайн ашиглалтын 30 жилийн хугацаанд нийт 1,861.5 мян.$м^3$ хөрс хуулж 14,172.53 мян.$м^3$ дайрга олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.13 $м^3/м^3$ байна.

*Тоног төхөөрөмж*: Ил уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн сонголтыг төсөл боловсруулагчийн ажлын даалгаварт тусгасны дагуу одоо ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглахаар төсөлд тусгасан. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд Shantui SD-13 маркийн бульдозер-1 ш, CATERPILLAR - 330 маркийн экскаватор 2ш, 25 тн даацтай Howo маркийн автосамосвал нийт 11 ширхэг, Liugong 855H маркийн дугуйт ачигч-1ш ажиллана.

### 1.6. *Ухаж, ачих процесс*

Уурхайн хөрс хуулалтын дундаж коэффициент 0.14 $м^3/м^3$ буюу хөрс хуулалт бага, уул техникийн хүндрэлгүй, олборлолт, ашиглалт явуулахад хялбар орд юм. Уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын ажилд дараах тоног төхөөрөмжийн хослол ажиллана.

*Олборлолтын тоног төхөөрөмж*

CATERPILLAR 330 маркийн 1.8 $м^3$ утгуурын багтаамжтай экскаватор, Howo маркийн 25 тн даацтай автосамосвал.

Уурхайн хөрс хуулалт, дайрга олборлолтонд CAT330 маркийн 1.8 $м^3$ утгуурын багтаамжтай экскаватор 2 ширхэг ажиллах бөгөөд эдгээр техникийн бүтээл ордын хөрс, дайрга (сийрэгжилт тооцсон) олборлоход бүрэн хүрэлцээтэй байна.

### 1.7. *Уурхайн тээвэр*

Ил уурхайгаас хуулах хөрс болон олборлох дайргыг автосамосвалаар тээвэрлэж хөрсийг гадаад болон дотоод овоолго, дайргыг бутлан ангилах хэсгийн түр овоолгод хураана.

Дотоод тээвэрт Солонгос улсад үйлдвэрлэсэн Howo маркийн 25 тн даацтай автосамосвалууд ашиглахаар төлөвлөсөн.

Ил уурхайн ашиглалтын ахилт гүнзгийрэлтээс хамааран тээврийн зай жил тус бүр харилцан адилгүй байх ба үүнээс шалтгаалан тээврийн бүтээл, автосомасвалын тоо ширхэг жил тус бүр харилцан адилгүй гарна.

*Хөрс тээвэр*. Хөрсийг гадаад ашиглалтын эхний жилүүдэд ил уурхайн хоосон орон зай үүстэд гадаад овоолгод хураана. Мөн шимт хөрсийг тусд хуулж шимт хөрсний овоолгод хураана.

Хөрсний овоолгод хураагдах сийрэг хөрсний хэмжээ болон экскаваторын тасралтгүй ажиллагааг хангах нөхцөлтэй уялдуулан хөрс тээвэрлэх автосамосвалын тоог тооцсон.

*Дайрга тээвэр*. Ил уурхайгаас олборлох дайргыг бутлан ангилах хэсгийн түр овоолго хүртэл тээвэрлэн хураана.

*Шимт хөрс хуулах*. Шимт хөрсийг Shantui SD-13 маркийн бульдозероор хуулж экскаватороор автосамосвалд ачин уурхайн хүрээнээс 110 метрийн зайд шимт хөрсний овоолго руу тээвэрлэнэ. Шимт хөрсний овоолгыг 2 метрийн өндөртэй 300 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна.

Шимт хөрсийг уурхай, овоолгын суурийн талбайгаас 0.3 метрийн зузаантайгаар хуулна. Нийтдээ 123.0 мян.$м^3$ шимт хөрс хуулж овоолно.

### 1.8. *Овоолго:* Ил уурхайд Shantui SD-13 маркийн бага хүчин чадалтай бульдозер ашиглана.

*Замын ашиглалт, үйлчилгээний процесс:* Ил уурхайн дотоод болон гадаргуугийн замын ашиглалт үйлчилгээний ажилд компани өөрийн тоног төхөөрөмж болох Shantui SD23 бульдозер, Hyundai HD-65 усны машин, Liugong дугуйт ачигч зэргийг ашиглана.

*Хүснэгт №3. Ил уурхайн барилга байгууламжууд*

| № | Барилгын нэгж | Хэмжих нэгж | Хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | | Хотхон | | |
| 1 | Уурхайн удирдлагын байр | $м^2$ | 14 | 20 тн контейнер-хаус 1 ш |
| 2 | Ажилчдын сууц | $м^2$ | 57 | 40 тн контейнер-хаус 3 ш |
| 3 | Ажилчдын сууц | $м^2$ | 124.6 | 4 ш монгол гэр |
| 4 | Цайны газар | $м^2$ | 28.4 | 20 тн контейнер-хаус 1 ш |
| 5 | Халуун ус болон угаалга | $м^2$ | 30 | Сендвичин байр |
| | | Ил уурхай | | |
| 5 | Засварын газар, сэлбэгийн агуулах | $м^2$ | 28.4 | 40 тн контейнер 1 ш |
| 6 | Засварын талбай | $м^2$ | 100 | Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна |
| 7 | Түлшний ёмкост | тн | 15 | Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна |
| 8 | Тэсрэх бодисын агуулах | $м^2$ | 40 | Стандартын дагуу барина. |

## 1.9. Усан хангамж

### *1.9.1. Ажилчдын хотхон, унд ахуйн усны хэрэглээ*

Орд ашиглалтын нийт 30 жилийн хугацаанд уурхайн хотхонд 34-52 хүн амьдрана. Технологийн болон унд-ахуйн усыг Байгаль орчны Сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын дагуу “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах ус хэрэглээний түр норм”-ыг үндэслэн тооцоо хийв. Унд ахуйд хүн өдөрт 80 л ус хэрэглэхээр тооцсон. Уурхайн хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд нийт 30 жилийн хугацаанд 25,147.84 $м^3$ ус хэрэглэхээр байна.

### *1.9.2. Зам усалгаа*

Зам талбайн усалгааг 4-10 сарын хугацаанд (180 хоног) 7 хоногийн 3 өдөр нийт жилд 80 удаа усалгаа хийхээр тооцов. Иймд замын усалгааг Байгаль орчны Сайдын 2015 оны 301 дүгээр тушаалын дагуу тооцсон.

*Хүснэгт №4. Зам талбайн усалгааны норм*

| № | Усалгааны төрөл | Хэмжих нэгж | Усалгааны норм литр |
|---|---|---|---|
| 1 | Гудамж зам талбай | $м^2$ | 2.0 |

### *1.9.3. Төслийн нийт усны хэрэглээ*

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглахад шаардлагатай нийт усны хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт №5. Нийт усны хэрэглээ*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Нийт ашиглалтын жилд |
|---|---|---|---|
| 1 | Унд, ахуйн усны хэрэгцээ | $м^3$ | 25,147.84 |
| 2 | Зам талбайн усалгаа | $м^3$ | 55,232.0 |
| | Нийт усны хэрэгцээ | $м^3$ | 80,379.84 |

## 1.10. *Агуулах*

Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 5 хоногийн нөөц буюу 10 тн түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана.

## 1.11. *Засвар механикийн барилга байгууламж*

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын цехэд хийж гүйцэтгэнэ. Засварын цехэд дугуй засвар, гагнуур, кран, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.

## 1.12. *Цахилгаан хангамж*

***Цахилгаан хангамжийн эх үүсвэр:*** Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт байрлах Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг 110/35/10 кВ-ын Ярмаг дэд станцаас 35 кВ-ын Зуунмод А фидерийн Био салбар агаарын шугамын тулгаар №20-21 хооронд салбарлалтын

төмөр анкер тулгуур босгож салбар шугамын эхэнд хуурай салгуурын пункт суурилуулж агаарын шугам татаж тэжээх нөхцөлтэйгээр 15/02093/19 тоот техникийн нөхцөл 2 ширхэгийг гаргуулсан байна. Энэхүү техникийн нөхцөл тус бүрийн тооцооны чадал нь 600 кВА юм.

**Аянганаас хамгаалах байгууламж.** ШТМ-ын агуулах болон засварын талбай нь анхдагч болон хоёрдогч аянгын цохилтоос хамгаалагдсан байх ёстой. Анхдагч аянгын цохилтоос хамгаалах аянга зайлуулагч нь талбайгаас зайтай тусдаа газардуулгатай байх ёстой. Газардуулга нь $\emptyset - 12$ мм, 5 м–ийн урттай төмөр хоолой буюу эсвэл 50*50*5 мм, 3 м–ийн урттай гурвалжин төмрөөр хийгдсэн байх ба газрын гүнд 0.8 м-т 40*4 $мм^2$ төмөр туузан ил газардуулагатай холбогдсон байна.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*<u>Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:</u>*

- Ил уурхайн олборлолтын үед гарах тоосжилт,
- Тээвэрлэлтийн үеэс үүсэх тоосжилт,
- Уурхайн олборлолт, газар шорооны ажлаас үүсэх тоосжилт,
- Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох.

*Хүснэгт №6. Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Хэрэгжүүлсэн ажил | 2022 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /төгрөг/ | Биелэлт |
|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | |
| 1 | Ордын дотоод тээвэрлэлтийн замыг тоосжилт ихтэй үед усалж байх | - | Тээвэрлэлтийн зам, уурхай, кемп орчмыг тоосжилтоос сэргийлж тогтмол усаар шүршиж, усалж байсан. |
| 2 | Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, | 951,600 | . Техникийн үзлэгт хамруулсан баримтыг хавсаргав. |
| 3 | Засвар үйлчилгээг тогтмол хийх | - | Хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулж, засвар үйлчилгээг тогтмол хийлгэсэн |
| **Гадаргын ба газрын доорх усны нөөц** | | | |
| 1 | Ус ашигласны төлбөрийг зохих журмын дагуу тооцож орон нутгийн байгууллагад цаг хугацаанд нь төлөх | 278.5 | Ус ашиглах гэрээ байгуулсан тус компаний зүгээс ус ашиглах төлбөрийг тогтмол төлж байсан. Усны мөнгийг төлсөн баримтыг хавсаргав. |
| 2 | Шатах тослох материал алдагдах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | Дотоод төлөвлөлтөөр | Компанийн дотоод журамд байгалийн гэнэтийн эрсдэлийг урьдчилан тооцох, учирсан тохиолдолд яаралтай авах арга хэмжээний хөтөлбөр боловсруулан оруулсан. |
| **Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч** | | | |
| 1 | Эвдрэлд өртсөн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх | - | 2022 онд нөхөн сэргээлт хийгдэхгүй. |
| 2 | Зам арчилгааны зардал, эвдэрсэн тохиолдолд засах | Дотоод төлөвлөлтөөр | Эвдэрсэн зам талбай байхгүй. Эвдэрсэн тохиолдолд цаг тухай бүр засвар хийнэ. |
| 3 | Үйлдвэрлэлийн технологийн замын зураг гаргаж зөвхөн заасан замаар машин техникүүдийг зорчуулах, | Дотоод төлөвлөлтөөр | Машин техникүүд заагдсан замаараа зорчиж байгаа. Замын тэмдэг тэмдэглэгээний зургийг хавсаргав. |
| 4 | Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх | Дотоод төлөвлөлтөөр | Ил уурхайн талбайн хэмжээндээ ажиллаж байгаа. |
| **Ургамлан нөмрөг** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| **1** | Тоос үүсэх талбайг услах, олон салаа зам гаргахгүй гаргасан замаараа зорчих | - | Уурхайн зам талбайн тэмдэгжүүлэлтийн зургийг оруулав. |
| Нийт | | 1,230.100 | |




*Зураг №2. Уурхайд тавьсан, тэмдэг тэмдэгжүүлэлтийн зураг*

## 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нөхөн сэргээлтийн ажил 2022 онд барилгын чулууны ордод хийгдэхгүй.

## 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нийслэлийн Байгаль орчны газрын харъяа Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хороололд байрлах Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт зардлаар мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн баримтыг хавсаргав.

*Хүснэгт №7. Дүйцүүлэн хамгаалалын биелэлт*

| **№** | **Дүйцүүлэн хамгаалах зорилго** | **Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ** | | **Жилийн төсөв /мян.төг/** | **Хэрэгжүүлэгч** | **Биелэлт** |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах | ХУД 14-р хороо Өлзийт хорооны урд ДХ-ын төлөвлөгөөний төсөвт зардлаар мод тарих | | 5,955.0 | “Цээцээ импекс” ХХК, | Нийслэлийн БО-ны газрын гаргасан саналын дагуу НБОГ-ын харъяа Өлзийт хорооны урд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт ажилд хандив өгсөн. Санал болон уг хийгдсэн ажлын тайланг хавсаргав. |
| **Нийт зардал** | | | | **5,955.0** | | |

## 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

## 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Барилгын чулууны ордын эзэмшлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулсан.

## 7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Цэлцээ Импекс" ХХК-ийн "Морин-Уул" барилгын чулууны орд нь тэсэлгээний ажилд дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат "ANFO" "Аянга" зэрэг эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан ашигладаг. Тэсрэх материал тэсэлгээний хэрэгслийг хотын ойролцоо орших агуулахаас зөөж тээвэрлэн мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг. Тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөл бүхий тэсэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Пауэр бласт" ХХК-р хийлгэхээр төлөвлөж байгаа бөгөөд 1 удаагийн тэсэлгээнд шаардагдах тэсрэх бодис, материалыг холбогдох байгууллагууд түүний агуулах үйлдвэрээс худалдан, тээвэрлэн авч ирж тэсэлгээг хийнэ. Гэрээг хавсаргав.

## 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдлээс үүсэх сөрөг нөлөөлөл:

- Болзошгүй аюул, осол, аваар гарах,
- Техник технологийн шугам сүлжээний гэмтэл,
- Галын гэнэтийн аюул үүсэх,
- Байгалийн гамшиг үүсэх,
- Ажилчдын эрүүл мэнд муудах.

*Хүснэгт №8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хэрэгжүүлсэн ажил | 2022 онд БОМТБ – нд зарцуулсан зардал /мян.төг/ | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | - | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж хяналт тавьж ажилласан. |
| 2 | Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны зардалд багтсан | Ажилчдад галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан. Ажилчдын байр зэрэг зохих газруудад гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж, самбар тэмдэг тэмдэглэгээг хадсан. |
| 3 | Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах | Үйл ажиллагааны зардалд багтсан | |



*Зураг №3. Галын аюулгүй байдлын тухай сургалт зохион байгуулж буй фото зураг*




*Зураг №4. Уурхай дахь галын булангийн фото зураг*




*Зураг 5. Галын булан, гал унтраах хэрэгслүүдийн фото зургууд*

## 9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлыг Хан-Уул дүүргийн "Хан Эко Тээвэр" ОНӨААТҮГ-тэй гэрээ байгуулсаны дагуу хог хаягдлыг тээвэрлүүлнэ.

*Хүснэгт №9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хэрэгжүүлсэн ажил | 2022 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/ | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх | 150.0 | Гэрээний дагуу хог хаягдлыг харьяа дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан сар бүр тээвэрлүүлдэг. Гэрээг хавсаргав. |
| **Нийт** | | **150.0** | |



*Зураг №5. Хог хаягдлын хашаалсан байдал*

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь "Цэзцээ импекс" ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасадаг баримт бичиг юм.

Морин уулын барилгын чулууны ордын төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ. Тухайн төслийг хэрэгжүүлэх явцад ус, хөрс, агаарт үүсэх бохирдол, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бүрт орох аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц дээж авах болон хэмжилт хийх цэгийн байршил, шинжилгээгээр тодорхойлох үзүүлэлтүүд шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах хэлбэр зэргийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нарийвчлан тусгана. Үүний дагуу "Цээцээ импекс" ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох ус, хөрс, агаарт БОМТ-нд тусгасны дагуу хяналт шинжилгээг зайлшгүй хийх шаардлагатай. БОХШХ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Морин уулын барилгын чулууны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлсны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

*Хүснэгт №10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлтүүд | Биелэлт | Зардал /мян.төг/ |
|---|---|---|---|
| | | **Агаарын орчин** | |
| 1 | Агаар дахь (TSP, PM10, PM2,5) ханаагүй тоосны дээж авч шинжлүүлэх | Бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхайгаас дээж авч шинжилгээ хийлгүүлсэн. | - |
| 2 | Дуу чимээ, агаарын чийгшил, хөрсний температур хэмжих | Бутлуур, ил уурхай, уурхайн кемп суурьшилын бус буюу үйлдвэрээс 1200 метр орчмоос дуу шуугианы дээж авч "Хэлт энд сэфти солушинс" ХХК-ны эрүүл ахуй хор судлалын лабораториор хийлгүүлсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргав. | |
| | | **Хөрс** | |
| 3 | -Хөрсний химийн үзүүлэлт (pH, $EC_{2.5}$ dS/m, $P_2O_5$, $K_2O$, $CaCO_3$)<br>-Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co) | Уурхайн карьерийн гадна талаас зонхилох салхины чиглэлийн дагуу болон шатах тослох материалын агуулах, бохирдсон байж болох цэгүүдээс хөрсний дээж авч ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний шинжилгээний лабораториудад шинжлүүлсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан | Хөрсний ерөнхий шинжилгээ хүнд метал- 46.0 |
| | | **Ус** | |
| 3 | -Усны химийн шинжилгээ (pH, EC, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ ($CACO_3$) | Ахуйн хэрэглээний уснаас ерөнхий шинжилгээ авсан. Ундны уснаас дээж авч ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан | Ахуйн хэрэглээний ус 30.0 |
| | **Нийт** | | **1,298.4** |




*Зураг №6. Усны дээж авч байгаа үеийн зураглал*




*Зураг №7. Хөрсний дээж авч байгаа үеийн зураг*




*Зураг №1. Усны дээж авч байгаа үеийн зураг*

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллын өмнө хариуцан ажиллана.

*Хүснэгт №11. Удирдлагын байгууллагын талаар авч хэрэгжүүлэн арга хэмжээ*

| № | Хэрэгжүүлсэн ажил | 2022 онд БОМТБ-нд зарцуулсан зарадл /мян.төг/ | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр хангах | Үйл ажиллагааны зардалд орсон | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр бүрэн хангасан |
| 2 | Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран зохион байгуулах | | Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан. |
| 3 | Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах | | Ажилчдыг эмчийн үзлэгт хамруулсан зургийг хавсаргав. |
| 4 | БОМТ -ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч байх | - | БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч ажиллаж байна. |
| 5 | Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх | 5,500.0 | Байгаль орчны аудитыг "Мон газар консалтинг" ХХК-иар хийлгүүлсэн тайлангийн нүүрийг хавсаргав. |
| | Нийт | 5,500.0 | |



*Зураг №8. Ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас олгосон байдал*



*Зураг №9. Ажилчдын эмчийн үзлэгт орж байгаа байдал*

## 12. .ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Морин-уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөлөөлөлд шууд өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах үүргээ хэрэгжүүлэх зорилготой дараахь арга хэмжээг төлөвлөж, биелүүлэн ажиллаж байна.

*Хүснэгт №11. БОМТБ-ийн хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь*

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Мэдээний агуулга | Хугацааны тов | Зохион байгуулах газар | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | БОМТ-ний биелэлтийг Хан-Уул дүүрэгт тайлагнах | БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах | 11-р сар | БОАЖЯ болон сум / Хан-Уул дүүрэгт тайлагнах | ИТХурал болон дүүргийн иргэдэд тайлагнасан. |
| **2** | БОАЖЯ-ны ХБОБНУГ-т | Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх | 12-р сар | БОАЖЯ-нд | БОАЖЯ-нд БОМТ-ний тайлан батлуулахаар өгсөн байгаа. |

## 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

*Хүснэгт №12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зарсан зардал*

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зардал /мян.төг/ 2022 он |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 1,230.1 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | - |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 5,955.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - |
| 6 | Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | - |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 150.0 |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | 5,000.0 |
| 9 | БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | - |
| 10 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | 76.0 |
| Нийт | | 12,411.100 |

"Цэцээ Импекс" ХХК-ний Морин уулын барилгын чулууны ордыг ашиглах уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд 2022 онд нийт 12,411.100 мян.төг зарцуулсан бөгөөд бусад үйл ажиллагааны зардлыг дотоод төлөвлөлтөндөө оруулан тооцсон.

## ДҮГНЭЛТ

“Цэзцээ импекс” ХХК нь Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хийж гүйцэтгэлээ.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулллаа.

“Цэзцээ импекс” ХХК нь 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, цаг тухай бүрт шаардлагатай арга хэмжээнүүдийг авч сөрөг нөлөөллийг бууруулж ажилласан.

Мөн тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилтыг бууруулж тухай бүрт усалгаа хийж, ажилчдад хөдөлмөр хамгааллын арга хэмжээний зааварчилгаа өгч, агаар, ус, хөрсний шинжилгээнүүдийг тухай бүрт өгч, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг ажлуудыг хийж ажилласан.

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ


1. Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
2. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” –ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал /гарын авлага/ УБ 2014 он
4. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”.

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2008.02.13
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011137041
/Улсын бүртгэлийн дугаар/

2804816
/Регистрийн дугаар/

Цэоцэо-Импекс Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

| Шийдвэр | 1 | 2004.01.28 |
|---|---|---|
| /шийдвэрийн нэр/ | /дугаар/ | он, сар, өдөр |

511000 Гадаад худалдаа
/код/ /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/ /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

| Хугацаагүй | 2 | 1,000.0 |
|---|---|---|
| хугацаа | /гишүүдийн тоо/ | /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/ |

Сүхбаатар дүүрэг, 18-р хороо, Бэлхийн гудамж, 54 - 314, утас1:91913170, утас2:, факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДЭСНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЛБА УХА0175

Улсын бүртгэлийн алба
/бүртгэсэн байгууллагын нэр/

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН**

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 19/М017

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Нийслэлийн Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр Сондуулт нэртэй газарт орших 54.07 гектар талбайг хамарсан түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал олборлохыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011137041 тоот гэрчилгээтэй “Цэзцэз Импекс” ХХК –д энэхүү тусгай зөвшөөрлийг 2034.02.12 дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН БОХИРДЛЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН

2019 оны 02 сарын 12 өдөр
Улаанбаатар хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

Тусгай зөвшөөрлийн дугаар **19/M017**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

| Дэс дугаар | Хөдөлгөөний тайлбар | Гарын үсэг, огноо, тамга |
|---|---|---|
| 001 | • Бүртгэв: 2019.02.12-нд олгосон, 2034.02.12-нд дуусах тусгай зөвшөөрөл олгох<br>• НЗД-ийн 2019.02.01-ний А/71 дүгээр захирамж<br>• Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр төлөв. Хугацаа 2019.02.12-2020.02.12 хүртэл | 2019.02.12<br>НБОГ-ын дарга<br>Э.Баттулга<br>YOA0039 9077040 |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ**

Тусгай зөвшөөрлийн дугаар **19/M017**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/ | Хасагдах талбайн хэмжээ /га/ | Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | # | Уртраг | Өргөрөг |
| 001 | • 2019.02.12-нд олгосон, 2034.02.12-нд дуусах<br>• Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийн огноо: 2019.02.01 | 54.07 | 0 | 1 | 106°43'41.03"E | 47°48'40.00"N |
| | | | | 2 | 106°43'39.70"E | 47°48'50.87"N |
| | | | | 3 | 106°43"49.59"E | 47°48'58.00"N |
| | | | | 4 | 106°44'11.02"E | 47°48'58.00"N |
| | | | | 5 | 106°44'11.30"E | 47°48'40.00"N |
| | | | | | | |
| | | | | 1 | 106°42'50.00"E | 47°48'40.00"N |
| | | | | 2 | 106°43'36.25"E | 47°48'40.00"N |
| | | | | 3 | 106°43'32.78"E | 47°48'49.15"N |
| | | | | 4 | 106°43'30.35"E | 47°48'51.35"N |
| | | | | 5 | 106°43'22.44"E | 47°48'52.19"N |
| | | | | 6 | 106°43'15.21"E | 47°48'50.57"N |
| | | | | 7 | 106°43'13.70"E | 47°48'42.09"N |
| | | | | 8 | 106°43'11.15"E | 47°48'42.56"N |
| | | | | 9 | 106°43'05.89"E | 47°48'47.97"N |
| | | | | 10 | 106°43'02.95"E | 47°48'48.52"N |
| | | | | 11 | 106°43'00.96"E | 47°48'42.73"N |
| | | | | 12 | 106°42'59.27"E | 47°48'42.06"N |
| | | | | 13 | 106°42'50.00"E | 47°48'42.06"N |
| | | | | 2019.02.12 | | Э.Баттулга |
| | | | | | | |
| | | | | | | |

АЖ ҮЙЛДВЭР, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН

# ДҮГНЭЛТ

2019 оны 04 сарын 19 өдөр — Дугаар XX-07-05 — Улаанбаатар хот

*Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших "Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд"-д 2019 онд хийсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай*

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд хийсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгээр геологич Д.Батсайхан, Г.Төрбат, Б.Буянхишиг нарын боловсруулсан тайлан, уг тайлан дахь нөөцийн тооцоонд Монгол улсын зөвлөх геологич ...нгэрэл, Монгол Улсын зөвлөх инженер, Барилгын материалын технологич инженер ...гбанди нарын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах **ДҮГНЭЛТ**-ийг гаргав: Үүнд:

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших "Сондуулт" нэртэй 102.89 га талбай бүхий 15/RO23 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг анх Нийслэлийн засаг ... бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн ... дүгээр захирамжаар "Эрдэс плазм" ХХК-д олгосон байдаг бөгөөд Улаанбаатар ... Байгаль орчны газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/65 тоот ...аар Сондуулт нэртэй түгээмэл тархацтай ашигт малтмалын 15/RO23 тоот ...лын тусгай зөвшөөрлийг "Цэвцээ Импекс" ХХК-д бүхэлд нь шилжүүлсэн байдаг.

Дээрх түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд ...лын ажлыг гүйцэтгэн барилгын чулууны нөөцийг бүртгүүлж тус нөөц бүртгүүлсэн ... "Сондуулт" нэртэй 54.07 га талбай бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын ...7 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Нийслэлийн засаг даргын 2019 оны 02 ... сарын 01-ний өдрийн А/71 дүгээр захирамжын дагуу "Цэвцээ Импекс" ХХК-д 2019 ...2 дугаар сарын 12-ны өдөр олгосон байдаг.

Тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 10-р хороо, ... төвөөс баруун урагш 30 км-т номинклатурын L-48-10 хавтгайд оршино.

"Цэвцээ Импекс" ХХК нь "Сондуулт" нэртэй түгээмэл тархацтай ашигт малтмалын ...7 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 2019 онд гүйцээх хайгуулын ... гүйцэтгэж геологийн нөөцийг бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр ...ж, геологи-хайгуулын ажилд нийт 126 915 800 төгрөг зарцуулсан байна.

3. 1960 онд геологич Н.В.Чернышев Улаанбаатар хот орчмын талбайд барилгын ... тоосгоны шаврын эрлийн ажил гүйцэтгэсэн бөгөөд 1990-1992 онд Т.Өнөдэлгэр,

Д.Банзрагч нарын Улаанбаатар хот орчим талбайд 1:50000-ны масштабтай гидрогеологи, агаарын геофизик, геофизик, геохимийн судалгааны иж бүрдэл эрлийн ажил гүйцэтгэжээ.

"Цэзцэз Импекс" ХХК нь 2017 онд "Сондуулт" талбайн баруун хэсэгт хайгуулын ажил гүйцэтгэн үр дүнгийн тайлан бичсэн бөгөөд "Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд" гэж нэрлэн 2017 онд нөөцийг B+C зэрэглэлээр 2382.57 мян.$м^3$ буюу 6313.8 мян.тн гэж тооцоолсон ба нөөцийн тооцоо бүхий тайланг ЭБМЗ-ийн хуралд хэлэлцүүлэн 2018 оны 07 сарын 05 өдрийн ХХ-09-12 дугаар дүгнэлт, АМГТГ-ын даргын 2018 оны 09 сарын 25 өдрийн н/109 дугаар тушаалаар нөөцийг бүртгүүлсэн байдаг.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын 19/М017 тоот тусгай зөвшөөрлийн талбайд миссисип Алтан-Овоо формацийн /$C_{1-2}ao$/ алевролитлаг жижиг дунд ширхэгтэй, алевропсаммитлаг структуртай, цул текстуртай зүүн хойш 80°-ын суналтай, баруун хойш 340°-ын азимутаар 40-50°-ын уналтай граувак элсэн чулуу тархсан байхаас гадна голоцены үеийн ($dpQ_{III-IV}$) элс, хайрга, шавар, элсэнцэр, дайргын хэмхдэс зэрэг чулуулгууд тархсан байдаг.

4. "Цэзцэз Импекс" ХХК нь 2017-2019 онд хээрийн хайгуул судалгааны ажлыг өөрийн хүчээр, 1:2000-ны масштабын байрзүйн зураглалын ажил болон цэг холболтын ажлыг "Од сүрвэй" ХХК, Баганат өрөмдлөгийн ажлыг "Легион дриллинг" зэрэг ХХК тус тус гүйцэтгэжээ.

Хайгуулын ажлын хүрээнд 150-200м х 350м-ийн торлолоор хайгуулын 5 шугамын дагуу 20-90 метрийн гүнтэй 12 цооног буюу 560.0 т/м баганат өрөмдлөгийн ажил хийж, ордоос нийт 100 дээж авсан бөгөөд БАК-ын лабораторид 88 ширхэг дээжийг физик-механикийн хураангуй шинжилгээнд, 12 ширхэг дээжийг физик-механикийн бүрэн шинжилгээ, бат бэх чанарын-2, элэгдэх чанарын шинжилгээ-5, химийн болон эрдсийн найрлага тодорхойлох шинжилгээнд тус тус 2 дээж, бетоны найрлага тодорхойлох шинжилгээнд (БАК-ын лаборатори-д) 1 дээж, МХЕГ-ын харъяа Үндэсний Аюулгүй Байдлын Лавлагаа Лаборатори (Цацрагын хяналтын шинжилгээ)-д 3 дээж, мөн 3 дээжинд петрографийн бүрэн бичиглэлийг Геологийн төв лабораторид тус тус шинжилгээнд хамруулсан байдаг.

5. Физик механикийн бүрэн шинжилгээний үр дүнгээр асгаасын нягт 1245 кг/$м^3$, ширхэгийн дундаж нягт 2.65 г/$см^3$, сүвэрхэг чанар 0.47 %, бутрамтгай чанар 5.2 %, бутлагдсан хэсэг 100 %, нимгэн үзүүрлэг хэсэг 5.2 %, тоос шавар шороон хэсгийн агуулга 0.2 %, бүхэл шавар байхгүй, ус шингээлт 0.45 %, органик хольц-шаардлага хангана, чийглэг 0.2 % зэрэг үзүүлэлттэй байна.

Мөн бат бэх шинж чанарын судалгаагаар (MNS 2998:2009, MNS 1272:99 стандартын дагуу) чийг 0.1%, эзлэхүүн жин 2.65 г/$см^3$, сүвэрхэг чанар 0.38 %, ус шингээлт 0.40 %, шахалтын бат бэх дунджаар 104.65 МПа, хүйтэн тэсвэрлэлт дундажаар 1.42%, урвалжих чадвар нь дунджаар шүлтийн концентрацийн бууралт 133.67 ммоль/л болон уусдаг цахиур /$SiO_2$/-ын агууламж 22.4 ммоль/л, элэгдэх чанарын хувьд 5 дээжинд хийсэн судалгаагаар 13.7%-15.6% хооронд хэлбэлзэж, дунджаар 14.9 % байна.

Ордын барилгын чулууны химийн найрлага нь $SiO_2$-ын агуулга дунджаар 73.1%, $Al_2O_3$ дунджаар 11.75%, $Fe_2O_3$ дунджаар 2.5%, CaO дунджаар 4.48%, MgO дунджаар 0.55%, $SO_3$ дунджаар 0.86% байна.

Цацраг идэвхжилийн судалгаагаар ордын чулуулаг дахь радийн эквивалент нь 110.0-174.0 Бк/кг, дунджаар 144.7 Бк/кг байна.

"Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд"-д зохих лабораторийн шинжилгээ, туршилт хийлгэсний үр дүнг технологийн шаардлагатай харьцуулж үзсэнээр тус ордын барилгын чулууны түүхий эд нь зам, барилгын чулуу, дайргаар ашиглах боломжтой нь тогтоогдсон ба MNS 2803-2004 стандартын дагуу М400 болон түүнээс дээш маркийн бетон эдлэхүүн үйлдвэрлэж боломжтой гэж үзжээ.

6. Зохиогчид Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын геологийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 15736.05 мян.$м^3$ (41.70 сая.тн)-ээр, боломжтой (С) зэрэглэлээр 3664.27 мян.$м^3$ (9.71 сая.тн)-ээр, нийт бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 19400.32 мян.$м^3$ (51.41 сая.тн)-ээр тооцоолжээ.

Шинжээч дээрх нөөцийн тооцоог хянаж, дахин тооцоод ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээж авахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж үзэв.

7. Ордыг ашиглах үеийн ундны усыг ойролцоох худгаас авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд ил аргаар олборлон орд ашиглах явцад үйлдвэрлэлийн хэрэгцээнд ус шаардагдахгүй гэж үзсэн.

8. Ордыг ашиглах техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр ордыг ил аргаар, тээвэртэй ашиглалтын системээр нийт 30 жилийн хугацаанд ашиглах бөгөөд жилд 543 мян.$м^3$ дайрга олборлон, нийт 15.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатайгаас ордыг ашиглаж эхлэхэд 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх ба хөрөнгө оруулалтаа 4.1 жилд нөхнө гэж тооцоолжээ.

9. Цаашид техник-эдийн засгийн үнэлгээг боловсруулахдаа байгаль орчны үнэлгээнүүд, ТЭЗҮ-ийг эрх бүхий байгууллагаар үндэслэлтэй боловсруулах, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг төлөвлөгөөний дагуу хийх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

*Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ, АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг АМГТГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:*

Нэг. "Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин Уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд хийсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайлан дахь (2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар) барилгын чулууны геологийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 15736.05 мян.$м^3$ (41.70 сая.тн)-ээр, боломжтой (С) зэрэглэлээр 3664.27 мян.$м^3$ (9.71 сая.тн)-ээр, нийт бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 19400.32 мян.$м^3$ (51.41 сая.тн)-ээр энэхүү дүгнэлтийн хавсралт дахь хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан барилгын чулууны ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Гурав. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан ЭБМЗ-ийн 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн XX-09-12 дугаар дүгнэлтээр ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн Морин уулын өмнөд хэсгийн дайрганы ордын түгээмэл тархацтай ашигт малтмалын 19/M017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой (B) зэрэглэлээр 940.18 мян.$м^3$ (2.49 сая.тн), боломжтой (C) зэрэглэлээр 160.67 мян.$м^3$ (0.425 сая.тн), нийт бодитой болон боломжтой (B+C) 1100.84 мян.$м^3$ (2.917 сая.тн) барилгын чулууны нөөцийг тус тус хасч нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Дөрөв. Энэхүү дүгнэлтийн 9-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг "Цэецэ импекс" XXK (Э.Гантуяа)-д анхааруулах.

Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Цэецэ импекс" XXK (Э.Гантуяа)-д даалгах.

Зургаа. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин Уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайлангийн боловсруулалтын ажлыг "Цариг ресурс" XXK, түүний геологич Д.Батсайхан, Г.Төрбат, Б.Буянхишиг, лабораторийн шинжилгээг Барилга архитектур корпорацийн лаборатори, Геологийн төв лаборатори, 1:2000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг "Од сүрвэй" XXK, тайлан, түүн дэх нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг шинжээч МУ-ын зөвлөх геологич С.Алтангэрэл, хайгуулын ажлын үнэн бодит байдал, бүх төрлийн дээжлэлтийг "Цэецэ импекс" XXK тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:
ЭБМЗ-ИЙН ДАРГА Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ ДАРГА Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БАЯРСАЙХАН

## “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ын нөөцийн тодотгол тооцооны нэгдсэн хүснэгт

(Ордын нөөц 2019 оны 03 дугаар сарын 15-ны байдлаар)
/Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 19/M017/

Хүснэгт №1

| № | Нөөцийн зэрэглэл, хэсэгшлийн дугаар | зузаан, м | | Талбай, мян.$м^2$ | Хөрсний ээлхүүн, мян.$м^3$ | Хэсэгшлийн ээлхүүн, мян.$м^3$ | Нөөц, мян.тн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөрс | чулуулаг | | | | |
| 1 | B-1 | 2.3 | 29.3 | 29.56 | 68.69 | 867.43 | 2,298.68 |
| 2 | B-2 | 2.1 | 35.7 | 10.67 | 22.89 | 380.91 | 1,009.41 |
| 3 | B-3 | 2.3 | 42.3 | 94.68 | 221.15 | 4,004.11 | 10,610.89 |
| 4 | B-4 | 2.2 | 48.2 | 37.20 | 82.77 | 1,792.52 | 4,750.19 |
| 5 | B-5 | 2.3 | 44.7 | 114.37 | 268.45 | 5,113.93 | 13,551.91 |
| 6 | B-6 | 2.2 | 45.2 | 79.23 | 170.58 | 3,577.15 | 9,479.44 |
| 7 | C-1 | 2.5 | 19.1 | 4.01 | 9.83 | 76.72 | 203.31 |
| 8 | C-2 | 1.3 | 35.1 | 1.73 | 2.23 | 60.51 | 160.34 |
| 9 | C-3 | 1.4 | 36.1 | 1.73 | 2.36 | 62.45 | 165.48 |
| 10 | C-4 | 2.7 | 21.6 | 12.92 | 34.29 | 279.41 | 740.43 |
| 11 | C-5 | 2.4 | 48.5 | 6.80 | 16.00 | 329.59 | 873.41 |
| 12 | C-6 | 2.5 | 20.2 | 0.96 | 2.44 | 19.42 | 51.46 |
| 13 | C-7 | 2.2 | 59.4 | 2.33 | 5.19 | 138.16 | 366.13 |
| 14 | C-8 | 2.3 | 37.1 | 26.43 | 62.08 | 981.18 | 2,600.12 |
| 15 | C-9 | 2.3 | 42.3 | 8.68 | 20.17 | 367.16 | 972.98 |
| 16 | C-10 | 2.2 | 29.7 | 25.59 | 55.82 | 759.84 | 2,013.58 |
| 17 | C-11 | 2.1 | 40.7 | 7.44 | 15.59 | 302.49 | 801.60 |
| 18 | C-12 | 2.2 | 24.9 | 11.56 | 25.22 | 287.35 | 761.49 |
| Бодитой B нөөц | | | | 365.71 | 834.53 | 15,736.05 | 41,700.52 |
| Боломжтой C нөөц | | | | 110.17 | 251.21 | 3,664.27 | 9,710.32 |
| Нийт B+C нөөц | | | | 475.88 | 1,085.74 | 19,400.32 | 51,410.84 |

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 18 өдөр | Дугаар Н/59 | Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн XX-07-05 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших 19/M017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сондуулт нэртэй талбайн Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайлан дахь геологийн нөөцийг нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 19,400.32 мян.м$^3$ буюу 51.41 сая.тн-оор хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Н.Мөнхбилэг/-д зөвшөөрсүгэй.

3. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордод 2019 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуул, нөөцийн дахин үнэлгээ, тодотгол тооцооны үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Цэзцэз импекс" ХХК /Э.Гантуяа/-д даалгасугай.

ДАРГА Х.ХЭРЛЭН

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2019.02.02 № 13/794

танай ____________-ны №____________-т

"ЦЭЭЦЭЭ ИМПЕКС" ХХК-Д

Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай

